



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/41

Ховд

Б.Ганболдод ажил хавсран гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, 33.5, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.и, 29 дүгээр зүйлийн 29.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 50 дугаар зүйлийн 50.1, Засгийн газрын 2003 оны 5 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Ганболдод аймгийн Улсын дайчилгааны төлөвлөгөө хариуцсан мэргэжилтний ажлыг 2019 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хавсран гүйцэтгүүлсүгэй.

2.Аймаг, сумдын дайчилгааны төлөвлөгөөг тодотгох, даалгаваржуулах, хадгалж, хамгаалан ажиллахдаа нууцын горимыг сахин ажиллахыг Б.Ганболдод үүрэг болгосугай.

3.Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг хавсралтаар баталж, ажлыг 2019 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хүлээлцүүлэхийг ажлын хэсэг /Б.Ганхуяг/-т даалгасугай.

4.Б.Ганболдод ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг үндсэн цалингийн 30 хувиар тооцож, 2019 оны 4 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн сар бүр олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

02 2019 тг А/41 Сн 215

Аймгийн Засаг даргын Тамгын
газрын даргын 2019 оны 3
дугаар сарын 29-ний өдрийн
А/41 дүгээр тушаалын хавсралт



УЛСЫН ДАЙЧИЛГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТНИЙ АЖИЛ ХҮЛЭЭЛЦҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ганхуяг-Цэргийн штабын дарга

Гишүүдэд: Б.Батмөнх-Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер

Д.Одгэрэл –Цэргийн штабын дайчилгааны офицер

-оОо-